



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯН-АГТ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/02/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.4.1 Мөнгөн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.2 Авлага	Error! Bookmark not defined.
3.5.3 Урьдчилгаа	Error! Bookmark not defined.
3.5.4 Бараа материал	Error! Bookmark not defined.
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.6 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.7 Өр төлбөр	Error! Bookmark not defined.
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	Error! Bookmark not defined.
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	7
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.03.25

№

344

танай

ны №

т

БАЯН-АГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БЯМБАЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баян-Агт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан, Засаг даргын харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын асуудалтай холбоотой нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 71.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11.4 сая төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархаагүй тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон 19.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, сангаас зээл олгох эрх зүйн шийдвэргүйгээр багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн олгосон;
- Сумын тэжээлийн нөөц бэлтгэх зорилгоор 50 га-д тариалах ногоон тэжээлийн үрийн тээврийн хөлсийг 1.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулахдаа тээвэрлэх замын маршрутыг тодорхой тусгаагүй;
- Дотоод хяналт хангалтгүйгээс харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил зэрэг нь НББ ийн тухай 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.2.4, 20.2.6, 20.2.9, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 23.6, 58.1.1, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолын 3.6.11, 3.6.8, 4.4.3.4, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал, дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоол, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.3, УСНББОУС 1, нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6326050574

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Агт сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн аудиттай холбоотой нийт 128.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн, ЗДТГ-ын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа зориулалт бус зарцуулах, жил бүр дахин давтагдах шинжтэй буюу төлөвлөх боломжтой зардалд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, тухай сангаас олгох зээлийг хэрхэн олгох талаар эрх зүйн акт байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Баян-Агт сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төсвийн төвлөрүүлэн захирагч 8 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2,769.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,308.8 сая төгрөгийг зарцуулжээ.

Баян-Агт сумын ИТХ-ын Х/03 дугаар тогтоолоор сумын Засаг даргын үйл ажиллагааны "Нээлттэй оролцоотой Баян-Агт сум" мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 87.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/Мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,235,713.0	1,099,191.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,089,571.8	5,206,730.1
	Нийт хөрөнгийн дүн	5,325,284.8	6,305,921.0
	Нийт өр төлбөрийн дүн	1,896.5	15,525.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,323,387.8	6,290,395.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,325,284.4	6,305,921.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,382,779.7	3,694,095.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,832,096.1	2,263,702.5
	Үйл ажиллагааны үр дүн	1,550,683.6	1,430,393.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	(311,143.2)	(463,385.6)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,239,540.4	967,007.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,083,847.4	5,323,387.8
	Тайлант оны үр дүн	1,239,540.4	967,007.4
	Эцсийн үлдэгдэл	5,323,387.8	6,290,395.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,464,704.7	2,472,516.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,673,747.7	1,935,286.5
	Үйл ажиллагааны ЦМГ	721,791.2	503,568.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(351,334.1)	(394,124.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(2,250.0)	(134,702.3)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	368,207.1	(25,258.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	381,432.3	749,639.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	749,639.4	724,381.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,288,517.4	2,308,898.4
	Урсгал зардал	1,681,349.6	1,915,312.8
	Хөрөнгийн зардал	607,167.8	393,585.6
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,288,517.4	2,308,898.4
	Улсын төсвөөс санхүүжих	2,231,217.4	2,193,112.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	57,300.0	115,785.5

Гурав. Аудитын илрүүлэлт

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 329.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөрчилд¹ 180.0 сая төгрөгийн алдааг залруулж, 87.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 62.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 226.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 16.5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 39.4 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 151.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данс:

Илрүүлэлт:

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон 19.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, сангаас зээл олгох эрх зүйн актгүй багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн олгож байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллан авлагыг барагдуулах, ЖДҮДС-гаас зээл олгох эрх зүйн актыг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2. Нийт зардал:

Илрүүлэлт:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд нийт 21.0 сая төгрөгийг зарцуулаагүй /ан амьтан, байгалийн ургамал/ нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хуульд заасны дагуу тухайн байгалийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, зарцуулах.

Илрүүлэлт:

Сумын тэжээлийн нөөц бэлтгэх зорилгоор 50 гад тариалах ногоон тэжээлийн үрийн тээврийг 1.4 сая төгрөгөөр байгуулахдаа гэрээнд зарим нөхцөлийг тодорхой тусгаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хуулийн дагуу гэрээний нөхцөлийг гэрээнд бүрэн тусгах, Нягтлан бодох бүртгэлийн хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Илрүүлэлт:

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас ногоон тэжээл тарьж иргэдэд зах зээлийн үнээр худалдан борлуулсан гэх боловч төсөвт өртгийн тооцоолол, хурааж авсан тэжээлийн тоо хэмжээ, худалдан борлуулсан гэх анхан шатны хангалттай зохистой нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт байхгүй байгаа нь санхүүгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ТТЗ	1	180.03			1	180.03	1	180.03				
Соёлын төв	1	0			1		1					
Дүн	2	180.03	0	0	2	180.03	2	180.03	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	21.2					2	21.2				
ЗДТГ	8	46.89	3	12.59	3	23.26	2	11.04				
Соёлын төв	2	3.74	1	1.28	1	2.46						
Дүн	12	71.83	4	13.87	4	25.72	4	32.24	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	6.69					1	6.69
Соёлын төв	1	2.49					1	2.49
ХХС	1	110					1	110
Нийт дүн	3	119.18	0	0	0	0	3	119.18
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	4	128.55			2	87.12	2	41.43
ЗДТГ	3	5.828	2	2.63	1	3.198		
ИТХ	2	3.49			1	3.49	1	
ОНХС	2	27.82			1	7.0	1	20.82
ХХС	1	0					1	
Нийт дүн	12	165.69	2	2.63	5	100.81	5	62.25
Бүгд дүн	15	284.87	2	2.63	5	100.808	8	181.43